



**“МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨХХК-ИЙН  
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**MongoREFINERY**  
ENERGY FLOWS WHERE INTENTION GOES

Улаанбаатар хот  
2023.01.10

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК (“МГТБҮ” ТӨХХК) нь “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл”-ийг 2017 оноос хойш үе шаттайгаар хэрэгжүүлж, эдүгээ төлөвлөлт, инженерчлэлээс бүтээн байгуулалтын үе шатанд шилжүүлж, 2025-2026 онд ашигпалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Хэдийгээр Covid-19 цар тахалтай холбоотойгоор хөрш улс орнуудад хорио цээрийн дэглэм тогтоож, хил гааль хаалттай байсан ч газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажил амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд 2022 онд Үйлдвэрийн Технологийн бус барилга байгууламжийн багц ажлын (EPC 01) барилга угсралтын ажил эрчимтэй явагдаж, EPC 02, EPC 03 багц ажлуудын инженерчлэлийг дуусгаж, ерөнхий гүйцэтгэгч болон технологийн Лиценз эзэмшигчдийг сонгон шалгаруулан, гэрээ байгуулж, инженерийн зураг төслийг боловсруулах зэрэг үйлдвэрийн төсөлтэй шууд холбоотой нэн чухал ажлуудыг хийж гүйцэтгэснээс гадна Түүхий тос дамжуулах хоолой, “Газрын тосны үйлдвэрийн хотхон”-ы бүтээн байгуулалтын ажил, Газрын тосны хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах бааз суурийг бий болгох, нарийн мэргэжлийн инженеруудийг бэлтгэх зэрэг ажлуудыг ихээхэн хүндрэл бэрхшээлийг даван туулж, хүчин чармайлт гарган ажилласны үр дүнд үйлдвэрийн бүтээн байгуулалт өнөөдрийн үе шатанд хүрсэн. Тухайлбал:

- “Монгол улсад газрын тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж, барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах” тендерт БНХАУ-ын төрийн өмчит “Норинко интернэйшнл Кооперейшн” компани шалгарч 2022.04.21-ний өдөр MR-01/2022 дугаартай Газрын тос дамжуулах хоолойн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх (EPC) гэрээ байгууллаа. Тус компани нь газрын тос дамжуулах хоолойн хөрөнгө оруулалтыг Монголоос нүүрс худалдан авах замаар шийдвэрлэх санал ирүүлснийг Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн бөгөөд Төслийн захиалагч УУХҮЯ, төслийн санхүүжүүлэгч “ЭТТ” ХК, төсөл хэрэгжүүлэгч “МГТБҮ” ТӨХХК болон төслийн гүйцэтгэгч БНХАУ-ын төрийн өмчит “Норинко интернэйшнл Кооперейшн” компаниудын хооронд 2022.04.18-ны өдөр “Хамтран ажиллах гэрээ” байгуулж, 32 сарын хугацаанд барилга угсралтын ажлыг гүйцэтгэн 2025 онд хүлээлгэн өгөхөөр ажлаа эхлүүллээ.
- Технологийн байгууламжуудын лиценз эзэмшигчээр шалгарсан АНУ, Франц, Итали, Нидерландын компаниудтай гэрээ байгуулах ажил бүрэн дуусч, лицензтэй байгууламжуудын ерөнхий зураг төсөл, инженерчлэлийн багц ажил (Basic Design Engineering Package-BDEP)-уудыг эхлүүллээ.
- 2022 оны 10-р сарын 28-ны өдөр “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК “Megha Engineering and Infrastructures Limited” компанийт EPC 02, 03 багц ажлын “Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын гэрээ” байгуулсан.

Мөн үйлдвэрийг барихад шаардлагатай бараа, ажил, үйлчилгээний 65 хувийг (анх 75 хувь байсан) Энэтхэг улсаас нийлүүлэхээр заасан байсныг EPC 01 багц ажлын хувьд уг хувь хэмжээг 55, EPC 02, 03 болон IV багц ажлын хувьд 50 хувь болгож буурууллаа.

### 1. ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтыг 4 хэсэгт хуваан хэрэгжүүлж байна. Үүнд:

- EPC-01: Технологийн бус барилга байгууламж
- EPC-02: Анхдагч процессын болон дагалдах байгууламж
- EPC-03: Үйлдвэрийн цахилгаан станц
- EPC-04: Лицензит технологийн байгууламж

Тайлбар: (EPC: Инженерчлэл-Худалдан авалт-Барилга угсралт)

## **EPC 01 багц ажлын талаар**

Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус барилга байгууламж (EPC 01)-ийн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын “Жэй Эм Си Прожект Индия” компанийн 280, туслан гүйцэтгэгч монголын 17 компаниас 350 хүн, нийт 630 орчим хүн үйлдвэрийн талбайд ажиллалаа.

EPC багц ажлын хүрээнд нарийвчилсан зураг төсөл боловсруулах, худалдан авалт, барилга угсралтын ажлууд хийгдсэн бөгөөд EPC 01 ажлын явц 77.85 орчим хувийн гүйцэтгэлтэй байна.

### **Барилга угсралтын ажлын явц:**

<b>№</b>	<b>Барилга байгууламж</b>	<b>Одоо хийгдэж байгаа ажил</b>	<b>Нийт ажлын явц</b>
1	Усны нөөцийн сав	Хучилтын хэв хашмал арматурчлал	98,7%
2	Оффис, сургалтын төв	1-р давхрын хучилтын бетон цутгалт	80%
3	Хоолны газар	Дотор гадна ханын блокон өргийн болон дотор цахилгааны сувагчлал	90%
4	Лаборатори	Дотор гадна ханын блокон өргийн болон дотор цахилгааны сувагчлал	89%
5	Анхан тусламж	Дотор гадна ханын блокон өргийн болон дотор цахилгааны сувагчлал	84%
6	Агуулах	1-р давхрын дам нурууны хэв хашмал арматурчлал	59%
7	Нэвтрэх хаалга-1	Хучилтын арматурчлал	83%
8	Нэвтрэх хаалга-2	Суурийн буцаан дүүргэлт, нягтуулалт	56%
9	Гал унтраах анги	Хучилтын бетон цутгалт	68%
10	Засварын цех	Суурийн буцаан дүүргэлт, нягтуулалт	51%
11	Үерийн ус цуглуулах талбай	Суурийн газар шорооны ажил	82,5%
12	Ус зайлцуулах хоолой	Газар шороо, арматурчлал, өргийн ажил	63%
13	Ус дамжуулах хоолой	Хана болон хучилтын арматурчлал, бетон цутгалт	95%
14	17км авто зам	Замын дүүргэлт, нягтуулалт, далангийн ажил	60,55%
15	Ус дамжуулах хоолой-Бор хөөвөр	Газар шороо болон хоолойн холболт гагнуур, буулгалт, буцаан булалт	72%
16	Өргөх насос станц	Суурийн дам нурууны арматурчлал	80%
17	11 худаг	Суурийн ажил болон дам нуруу, баганын арматурчлал, цутгалт	77%
18	ЦДАШ	35кВт,10кВт-ын хөндийрүүлэгч болон холболтын шугам угсралт	96%
19	Тос баригч байгууламж	Арматурчлал	54%





МГТБҮ-ийн инженерүүд, ТМЗ “Инженерс Индия Лимитед” компанийт хамтран ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж, “Жэй Эм Си Прожект Индия” компаниас ирүүлсэн ажлын зургуудыг 100% хянан баталгаажуулаад байна.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус барилга байгууламжийн ажилд шаардлагатай бараа материалын худалдан авалт 2022 онд төслийн талбай дээр нийт 88 контейнер, 5 вагон, трак ачааны машинаар 3, агаарын тээврээр нийт 11 удаагийн бараа материалын татан авалт хийгдсэн.

Барилга угсралтын ажилд шаардлагатай зарим бараа материал, техник, тоног төхөөрөмжийн татан авалт “Ковид-19” цар тахлын улмаас үүссэн ачаа тээврийн хүндрэлтэй нөхцөл байдал, улс орнуудад тогтоосон хорио цээрийн дэглэм зэргээс шалтгаалан саатаж, төслийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байгаа тул дараа дараагийн бүтээн байгуулалтын ажлыг цаг алдалгүй, эрчимтэй явуулахын тулд тээвэрлэлтийн хүндрэлтэй асуудлыг Хятадын талтай Засгийн газрын түвшинд яриа хэлэлцээ хийж, шийдвэрлэх шаардлага тулгарч байна.

## **EPC 02, 03 БАГЦ АЖЛЫН ТАЛААР**

EPC 02, 03-ын Ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2021 оны 4 ба 5 дугаар саруудад зарлаж, тендер хүлээн авах хугацааг удаа дараа сунгасны эцэст 2021 оны 12 дугаар сар, 2022 оны 1 дүгээр сард Энэтхэгийн компаниудаас хүлээн зөвшөөрөх боломжгүй өндөр үнийн санал ирүүлсэн.

Хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхийн тулд Монгол, Энэтхэгийг төр засгийн байгууллагуудтай холбогдож, шуурхай арга хэмжээнүүдийг авч ажилласан.

2022 оны 4-р сард БНЭУ-ын ЭКСИМ банк, Төслийн менежментийн зөвлөх (ТМЗ) компаниудыг Монголд урьж яриа хэлэлцээ хийсний үр дүнд эхний тендерүүдийг цуцлах, Энэтхэгийн ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн журамд манай төсөлтэй холбоотойгоор тусгайлсан өөрчлөлт оруулах замаар дараагийн шатны “Түргэвчилсэн тендер”-ийг зарлахаар болсон.

**2022.04.08-ны өдөр хуралдсан БНЭУ-ын Сайд нарын Нэгдсэн комиссын хуралдаанаар Монгол-Энэтхэгийн Засгийн газар хооронд хэрэгжүүлж буй стратегийн ач холбогдол бүхий төсөлд тулгамдсан асуудлыг хэлэлцэж, төслийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд манайхаас тавьсан хүсэлтүүдийг хүлээн авахаар болж, **Засгийн газрынхаа хөнгөлөлттэй зээлийн гүйцэтгэгчийг сонгон журамд өөрчлөлт** оруулсан.**

Тодруулбал, үйлдвэрийн бүтээн байгуулалтын гүйцэтгэгчийг зөвхөн Энэтхэгийн компаниудаас сонгох боломжтой байсан бол сонгон шалгаруулалтад Энэтхэгт бүртгэлтэй гадаадын компаниудыг оролцуулах нөхцөлийг бий болгосон.

**Ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Түргэвчилсэн тендер:**

Үйлдвэрийн Анхдагч процесийн болон Дагалдах байгууламж (EPC02)	Үйлдвэрийн Цахилгаан станц (EPC 03)
<ul style="list-style-type: none"> <li>2022.06.06 - Нэг үе шаттай “Түргэвчилсэн тендер” зарласан.</li> <li>2022.09.19 - Тендерийн материал хүлээн авсан.</li> <li>2022.09.26 - Үнийн санал нээсэн.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>2022.05.04 - Нэг үе шаттай “Түргэвчилсэн тендер” зарласан.</li> <li>2022.07.04 - Тендерийн материал хүлээн авсан.</li> <li>2022.07.21 - Үнийн санал нээсэн.</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>✓ 2022.10.10-13 - EPC 02, EPC 03 багц ажлын тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн БНЭУ-ын “Megha Engineering Infrastructure Limited” компанийтай Үнэ бууруулах хэлэлцээ хийсэн.</li> <li>✓ 2022.10.26 - Засгийн газрын хуралдаанаас шийдвэр гарсан.</li> <li>✓ 2022.10.28 - “Megha Engineering Infrastructure Limited” компанийтай Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын гэрээ байгуулсан.</li> </ul>	

Түргэвчилсэн тендерт эхний тендертэй харьцуулахад нэлээд хэмжээгээр буурсан үнийн дүнтэй саналууд хүлээн авсан ба Энэтхэгийн “Megha Engineering and Infrastructures Limited” компани EPC 02, 03-ын багц ажилд хамгийн бага үнийн санал ирүүлснийг Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтад тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн ахлагч Монгол Улсын Шадар сайдад танилцуулсан бөгөөд Шадар сайдаас тухайн компанийтай яаралтай хэлэлцээ хийж, гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх чиглэл өгсөн. Үүний дагуу манай компани “Megha Engineering and Infrastructures Limited” компанийг Монголд урьж, 2022 оны 10-р сарын 10-13-ны өдрүүдэд Үнэ бууруулах хэлэлцээ хийсэн бөгөөд дээрх 2 багц ажлын нийт үнийн дунг **111,38 сая ам.доллараар** бууруулсан.



Засгийн газрын 2022 оны 10-р сарын 26-ны өдрийн хуралдаанаар EPC 02, 03 багц ажлын тендерт шаардлага хангасан санал ирүүлсэн оролцогчтой гэрээ байгуулах шийдвэр гарсны дагуу “МГТБҮ” ТӨХХК-ийн ТҮЗ-өөс “Гэрээ байгуулах эрх олгох тухай” 2022 оны 12 дугаар тогтоолыг баталж, EPC 02 багц ажлыг гүйцэтгэх гэрээг БНЭУ-ын “Megha Engineering and Infrastructures Limited” компанийтай 598,900,000 ам.долларын үнийн дүнгээр, EPC 03 багц

ажлыг гүйцэтгэх гэрээг мөн “Megha Engineering and Infrastructures Limited” компанитай 189,720,000 ам.долларын үнийн дунгээр тус тус байгуулсан.

“МГТБҮ” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал, инженерүүд 2022 оны 10-р сарын 31-ний өдрөөс 11-р сарын 13-ны өдрүүдэд БНЭУ-д томилолтоор ажиллан EPC 02, EPC 03 багц ажлын Ерөнхий гүйцэтгэгч компанитай Менежментийн уулзалт хийж, тус компанийн хүнд аж үйлдвэрийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, хэрэгжүүлж буй зарим төсөлтэй танилцсан. Уг уулзалтаар багц ажлуудын нарийвчилсан, дэлгэрэнгүй төлөвлөгөөг гаргаж тохиролцоонд



хүрсэн. Үүнд:

- “MEIL” компани нь EPC 02, 03 багц ажлыг хариуцан ажиллах захирал болон хүний нөөц, бүтцийн талаар нарийвчлан тодорхойлж шинэчлэн ирүүлэхээр тохиролцсон.
- ТМЗ компани нь “MEIL” компанийн ирүүлсэн ажил гүйцэтгэх анхан шатны хуваарийг зохих шаардлагыг хангаагүй гэж үзсэн тул дахин боловсруулж ирүүлэхээр болсон.
- Барилга угсралтын ажлыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэхийн тулд Монголын цаг агаарын нөхцөлд тохируулсан нарийн төлөвлөгөө гаргах, ялангуяа өвлийн улиралд хийх ажлын хуваарь, төлөвлөгөөг үйл ажиллагаандaa уялдуулан ажиллахыг ТМЗ зүгээс “MEIL” компанид даалгасан.
- Тээвэрлэхэд хүндрэлтэй хэт том оврын тоног төхөөрөмжийн эд ангиуд, ган материалуудыг Монголд, үйлдвэрийн талбайд шууд үйлдвэрлэх асуудлыг тодорхойлохыг МГТБҮ болон ТМЗ зүгээс даалгасан. Одоогийн байдлаар “MEIL” компани шингэн шатдаг хий хадгалах дараалтат савнуудыг үйлдвэрийн талбайд үйлдвэрлэхээр төлөвлөж байгаагаа мэдэгдсэн.



Ерөнхий гүйцэтгэгчээр сонгогдсон “Megha Engineering Infrastructure Limited” компанийн төлөөлөл 2022 оны 11-р сард Монгол улсад ирж, үйлдвэрийн талбайн инженер геологи, судалгааны ажлаа эхлүүлээд байна.

#### Технологийн лиценз эзэмшигчдийг сонгон шалгаруулах ажлын талаар

Патенттай технологийн 7 байгууламжийн лиценз эзэмшигчдийг сонгон шалгаруулах тендер 2022 оны 1 дүгээр сард эцэслэгдэж, шалгарсан компаниудтай гэрээ байгуулж дууссан. Үүнд:

- 2022.04.01 - Хүхэр ялгах байгууламж (SRU)-ийн Лиценз эзэмшигчээр шалгарсан Бүгд Найрамдах Франц Улсын Axens компанитай
- 2022.04.01 - Устөрөгч үйлдвэрлэх байгууламж (HGU)-ийн лиценз эзэмшигчээр шалгарсан Италийн Kinetics Technology компанитай
- 2022.04.20 - Шингэрүүлсэн шатдаг хийг ялгах байгууламж (LPGTU)-ийн лиценз эзэмшигчээр шалгарсан АНУ-ын UOP компанитай
- 2022.04.21 - Дизелийн гидроцэвэрлэгээний байгууламж (DHDT)-ийн лиценз эзэмшигчээр шалгарсан АНУ-ын UOP компанитай
- 2022.05.10 - Бензин боловсруулах байгууламж (MS Block)-ийн лиценз эзэмшигчээр шалгарсан АНУ-ын UOP компанитай
- 2022.05.22 - Гидрокрекинг байгууламж (HCU)-ийн лиценз эзэмшигчээр шалгарсан АНУ-ын UOP компанитай
- 2022.06.10 - Висбрекинг байгууламж (VBU)- ийн лиценз эзэмшигчээр шалгарсан Голланд улсын Shell Global Solutions International компанитай тус тус байгуулсан.

Лиценз эзэмшигч компаниудтай гэрээ байгуулахаас өмнөх хэлэлцээний үе шатанд 4.6 сая. амдоллароор гэрээний үнийн дунг бууруулсан. Үүнд:

UOP Honeywell:	3.400.000 ам.доллар
Shell:	1.200.000 ам. доллар
Axens:	15,000 ам. доллар
Kinetics Technology:	61,500 ам.доллароор тус тус бууруулсан.

Байгууламж тус бүрээр Лиценз эзэмшигчидтэй гэрээ байгуулснаар лицензтэй байгууламжуудын ерөнхий зураг төсөл, инженерчлэлийн багц ажил (BDEP)-үүд эхэлж байгаа бөгөөд ТМЗ компанитай хамтран Лиценз эзэмшигч компаниудтай “Ажил эхлүүлэх уулзалт” (Kick-Off Meeting)-үүдүг цаг алдалгүй хийж, гэрээний талуудын харилцан тохиролцсон ажил гүйцэтгэх хуваарийн дагуу лиценз эзэмшигч нараас Ерөнхий зураг төсөл, инженерчлэлийн багцын бүрдэл баримт бичгийг хүлээн авч, ТМЗ компанитай хамтран хянаж, шаардлагатай техникийн уулзалтуудыг тухай бүрд нь амжилттай зохион байгуулж ажилласан.


№	Байгууламж	Ажил эхлүүлэх уулзалт (Kick-off meeting)	Технологийн схем хянах уулзалт (pfd review meeting)
1	Устөрөгч үйлдвэрлэх (HGU)	2021.11.19-11.25 2021.12.22	2022.03.02-03.07
2	Шингэрүүлсэн шатдаг хийн цэвэрлэгээ (LPGTU)	2022.04.26	2022.06.16,17
3	Дизелийн гидроцэвэрлэгээ (DHDT)	2022.04.28,29 2022.05.09	2022.07.19*
4	Гидрокрекинг (HCU)	2022.05.05,06 2022.05.09	2022.08.25*
5	Бензин үйлдвэрлэх (MS block)	2022.05.19,20 2022.05.26-06.02	2022.08.04*
6	Хүхэр ялгах (SRU)	2022.04.27	2022.06.23,24
7	Висбрекинг (VBU)	2022.06.20,21	2022.08.24*

ГТБҮ-ийн патенттай технологийн байгууламжийн нэг болох Устэрөгчийн үйлдвэрийн лиценз эзэмшигчээр Итали улсын “Кинетикс Технологи” компани шалгарч Ерөнхий зураг төсөл, инженерчлэлийн багцыг (BDEP) боловсруулж эхэлсэнтэй холбогдуулан, “МГТБҮ” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал, инженерүүд 2022.04.30-05.16-ны өдрүүдэд Итали улсад албан томилолтоор ажиллаж, тус үйлдвэрийн технологийн схем, шугам хоолойн диаграмм, тоноглолын техникийн баримт бичгүүдийг боловсруулахад санал солилцож ажилласан бөгөөд компанийн салбар хариуцсан удирдлага, мэргэжилтнүүдээс нарийн мэргэжлийн зөвлөгөө авч, үйлдвэрийг ажиллуулах программ, устэрөгчийн үйлдвэрийн шугам хоолойн инженерчлэл болон 3D зураг төсөл, реформерын зуухны бүтэц, ажиллах горим, тус байгууламжийн барилга угсралтын шатанд модульчилж тээвэрлэх боломжийг судалсан.



Мөн “МГТБҮ” ТӨХХК-ийн Процессийн албаны инженерүүд 2022.10.09-23-ны өдрүүдэд БНЭУ-д ажиллаж, ТМЗ компанийн инженерүүдтэй хамtran Бензин боловсруулах байгууламжийн лиценз эзэмшигч АНУ-ын Honeywell UOP-ийн салбар компанийтай тус байгууламжийн технологийн нарийвчилсан схем зургийг хянаж эцэслэн дараах ажлыг гүйцэтгэлээ. ТМЗ ба захиалагч талаас лиценз эзэмшигч Honeywell UOP компанийн боловсруулсан шугам хоолой, тоног төхөөрөмжийн схемийн эхний хувилбартай холбоотой Изомержуулэх, Нафта гидроцэвэрлэгээний, Риформингийн байгууламжууд дээр нийт 327 асуудлыг дэвшүүлсэн. Хурлын явцад лиценз эзэмшигч нь өөрсдийн боловсруулсан технологийн схем тус бүрээр танилцуулж, тайлбарласны дараа ТМЗ, захиалагч талуудын дэвшүүлсэн асуудлуудыг харилцан хэлэлцэх үед нэмэлт 47 асуулга гарсан бөгөөд холбогдох тайлбарыг хийж ярилцсаны үр дүнд схем зураг дээр шугам хоолой, хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн өөрчлөлтүүдийг тусгасан.





## ЕРС 04 БАГЦ АЖЛЫН ТАЛААР

Лиценз эзэмшигч компаниуд байгууламж тус бүрийнхээ зураг төсөл, инженерчлэлийн багцыг (BDEP) боловсруулж дууссан бөгөөд энэ нь тус багц ажлын тендерийн баримт бичгийн Техникийн хэсэг болж байна.

Манай компани ТМЗ компанийтай хамтран тендерийн 14 мянган хуудастай баримт бичгийг боловсруулснаар **ЕРС 04 багц ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2022.10.28-ны өдөр зарласан**. Тендерийг Энэтхэгийн ЭКСИМ банк болон Гадаад хэргийн яамтай зөвшилцсөний дагуу ЕРС II, III багцын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсантай ижил зарчмаар буюу **Түргэвчилсэн тендер** зохион байгуулахаар харилцан тохиролцсон.

Ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн материалд лиценз эзэмшигч компаниуд ("Shell Global solutions international B.V.", "Axens", "Honeywell UOP", "KT Kinetics Technology")-ын нууцлалын чанартай мэдээлэл багтаж буй тул тендерт оролцогчидтой Нууцлалын гэрээ байгуулах ажлыг ТМЗ компанийтай хамтран зохион байгуулсан.

 <p><b>MONGOL REFINERY</b></p> <p><b>EPC-04 (LICENSED UNITS)</b> FOR THE PROJECT TO CONSTRUCT A CRUDE OIL REFINERY PLANT IN MONGOLIA</p> <p><b>THE BIDDING DOCUMENT</b> SECTION – <b>1 COMMERCIAL SECTION</b> <b>SECTION – 2 TECHNICAL SECTION</b></p> <p>BIDDING DOCUMENT NO.: B285-000-EP-TN-9504/1014</p> <p>Approved by _____ Date _____ Dr. Altansetseg Daashdavaa, Executive Director Mongol Refinery State Owned LLC</p> <p>"MONGOL REFINERY" STATE OWNED LLC ULAANBAATAR, MONGOLIA</p>	 <p><b>MONGOL REFINERY</b></p> <p>Competitive Bidding for Crude Oil Refinery Plant in Mongolia Mongol Refinery State Owned LLC invites bids from eligible Indian bidders for the following works</p> <table border="1"> <thead> <tr> <th>Description</th> <th>Period for the availability of Bidding Document for pickup by the bidder</th> <th>Bid Due Date &amp; Time</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>EPC-04 (LICENSED UNITS) FOR THE PROJECT TO CONSTRUCT A CRUDE OIL REFINERY PLANT IN MONGOLIA (B285-000-EP-TN-9504/1014)</td> <td>From 28.10.2022 to 18.11.2022 10:00 - 12:00 Hrs (IST) and 14:00 - 16:00 Hrs (IST)</td> <td>12:00 Hrs (IST) on 28.03.2023</td> </tr> </tbody> </table> <p>Note:</p> <ul style="list-style-type: none"> <li>1. Bidding document can be picked up from the following address: The Embassy of Mongolia in New Delhi, India 34, Archbishop Makarios Marg New Delhi - 110 003, India (+91) 11-2463 1728 (+91) 11-2461 7989</li> <li>2. Bidder shall be required to enter into Non-Disclosure/Confidentiality Agreement (NDA) including Licensee specific NDAs (as required) executed by authorized personnel of Bidder with the Mongol Refinery State Owned LLC prior to issue of the Bidding Document.</li> </ul> <p>D Altansetseg Executive Director Mongol Refinery State Owned LLC</p>	Description	Period for the availability of Bidding Document for pickup by the bidder	Bid Due Date & Time	EPC-04 (LICENSED UNITS) FOR THE PROJECT TO CONSTRUCT A CRUDE OIL REFINERY PLANT IN MONGOLIA (B285-000-EP-TN-9504/1014)	From 28.10.2022 to 18.11.2022 10:00 - 12:00 Hrs (IST) and 14:00 - 16:00 Hrs (IST)	12:00 Hrs (IST) on 28.03.2023
Description	Period for the availability of Bidding Document for pickup by the bidder	Bid Due Date & Time					
EPC-04 (LICENSED UNITS) FOR THE PROJECT TO CONSTRUCT A CRUDE OIL REFINERY PLANT IN MONGOLIA (B285-000-EP-TN-9504/1014)	From 28.10.2022 to 18.11.2022 10:00 - 12:00 Hrs (IST) and 14:00 - 16:00 Hrs (IST)	12:00 Hrs (IST) on 28.03.2023					

Ингэснээр (ЕРС 02, 03 - Ерөнхий гүйцэтгэгч шалгарч ажлаа эхлүүлсэн, ЕРС 04 - Ерөнхий гүйцэтгэгчийн тендер зарлагдсан) Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүх технологийн байгууламжуудын нарийвчилсан зураг төсөл эхэлж, барилга угсралтын ажил ирэх оноос өрнөх нөхцөл бүрдэж байна.

## 2. “ГАЗРЫН ТОСНЫ ҮЙЛДВЭРИЙН ХОТХОН”-Ы БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

**Хотхоны I** ээлж болох 5 объектын (40-4, 95-1, 95-2, 32-9, оффис үйлчилгээний барилга) барилга угсралтын ажлын явц **79 хувьтай** байна. Ашиглалтад орсон 40-4 айлын орон сууцанд тавилга эд хогшил суурилуулж, тохижилтүүн ажлыг бүрэн дуусгасан. “Хангай Бигэр” ХХК-ийн хувьд Хөгжлийн банкны санхүүжилт тодорхой бус байгаагаас ажлаа дуусгахын

тулд өөр банкнаас зээл авч хариуцсан 95-1 айлын орон сууцны дотор, гадна заслын ажлыг үргэлжлүүлж байна.

“Хөгжлийн банк”-ны санхүүжилт зогссонтой холбоотойгоор Хотхоны I ээлжийн орон сууцны барилгууд (95-1, 95-2, 40-4, 32-9, оффис үйлчилгээний төв)-ын ажил зогссон хэвээр байна.

“Хотхоны гадна талбайн тохижилт, хашаа, автозам, явган зам, ногоон байгууламжийн ажил”-ийн гүйцэтгэгч компани мөн л Хөгжлийн банкны санхүүжилт зогссон улмаас 2 сарын хугацаанд ажил үргэлжлүүлэх боломжгүй нөхцөл байдалтай байсан. Харин 11-р сараас эхний санхүүжилт хийгдсэнээр авто замын хөрс хуулалт, гадна холбооны шугам хоолойн хүчинтгэл зэрэг ажлыг гүйцэтгэж, ус зайлцуулах хоолойн угсралтыг хийгээд байна.

**Хотхоны II ээлжийн орон сууцны барилгуудыг уг ажлын гүйцэтгэгч БХЯ-ны харьяа Зэвсэгт хүчний 339 дүгээр анги 2021 онд ашиглалтад оруулах гэрээгээр хүлээсэн үүрэгтэй хэдий ч өнөөдрийн байдлаар ажлын нийт гүйцэтгэл 32%-тай байна.**

Ажлаа эрчимжүүлэх, гэрээний үүргээ биелүүлэх шаардлагыг БХЯ болон Зэвсэгт хүчний 339 дүгээр ангид 2021 оны 7-р сараас хойш удаа дараа тавьсан ч ахиц гарсангүй өнөөг хүрсэн. Мөн барилга угсралтын ажил гүйцэтгэх турван талт гэрээний хугацаа 2021.09.16-ны өдөр дууссан ч гэрээ дүгнээгүй хэвээр байна. БХЯ-ны зүгээс асуудлыг шийдвэрлэхгүй байгаа нь нөхцөл байдлыг улам хүндрүүлж байна.

Зэвсэгт хүчний 339-р ангийн зүгээс гэрээний үнийн дүнг 16,0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл 21,0 орчим тэрбум төгрөгөөс 37,0 тэрбум болгон өсгөх шаардлага тавьж байгаа нь хамгийн хүндрэлтэй цаг үед гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн ажилласан бусад гүйцэтгэгч компаниудын хувьд (Хангай Бигэр ХХК, ТОБЭМ ХХК) шударга бус байгааг бидэнд мэдэгдээд байна.

Иймд “Газрын тосны үйлдвэрийн хотхон”-ы барилга угсралтын ажлыг түргэн шуурхай дуусгаж, зориулалтын дагуу ашиглах шаардлагатай байгаа тул хариуцагч байгууллага болох БХЯ-ны асуудлыг төр засгийн түвшинд танилцуулж, шийдвэр гаргуулан ажлыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар ЗГХЭГ-ын дарга Д.Амарбаясгаланд 2022.10.27 өдрийн албан бичгээр хандсан.

Мөн БХСайд Г.Сайханбаярт 2022.12.02-ны өдрийн 01/551 тоот албан бичгийг хүргүүлсэн бөгөөд барилгын ажил гүйцэтгэх гэрээг хууль тогтоомжийн хүрээнд дүгнэж дуусгах, материалын үнийн зөрүүний тооцоог ирүүлэх, урьдчилгаа төлбөрийн үлдэгдлийг төлж барагдуулах зэрэг арга хэмжээг авахыг дурдсан.

**Хотхоны цахилгаан хангамж, холбоо:** Тус ажлыг гүйцэтгэгч “Майнс Ап” ХХК нь гадна цахилгаан хангамжийн трасс, хуваарилах байгууламж болон дэд өртөөний барилга угсралтын ажлуудыг бүрэн дуусгаж, байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.

Харин гадна холбооны ажлыг шугамын трасс төв замтай огтлолцож буй тул Дорноговь аймгийн ЗДТГ-аас зөвшөөрөл олгогдсоны дараа 2023 онд үргэлжлүүлэхээр хүлээгдэж байна.

**Хотхоны гадна талбайн тохижилт:** “Газрын тосны үйлдвэрийн хотхон”-ы гадна талбайн тохижилт, хашаа, авто зам, явган зам, ногоон байгууламжийн ажлыг гүйцэтгэх багц-1 ажлын тендерт “Амьюс” ХХК шалгарч, ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан бөгөөд хотхоны доторх авто зам, замын гэрэлтүүлгийн ажлын зураг төслийн ажил болон инженерийн байгууламжийн хүчинтгэлийн ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн бөгөөд 2023 онд авто зам, замын гэрэлтүүлгийн ажил үргэлжилнэ.

“Газрын тосны үйлдвэрийн хотхон”-ы гадна талбайн тохижилт, хашаа, ногоон байгууламжийн ажлын багц-2 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендериийн баримт бичгийг боловсруулсан боловч Хөгжлийн банкны санхүүжилт зогссон улмаас тендериийг зарлаагүй байна.

### 3. ҮЙЛДВЭРИЙН ГАДНАХ ДЭД БҮТЭЦ

**Авто зам:** ЗТХөгжлийн сайдын 2021 оны А/147-р тушаалаар “Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулсан Газрын тос боловсруулах үйлдвэрийг Сайншанд хоттой холбох 17.5 км авто зам”-ыг тусгай зориулалтын авто замд хамруулсан тул уг авто замын арчлалт, хамгаалалтыг 2022 оноос ЗТХЯ-ны харьяа “Дорноговь АЗЗА” ТӨХК

хариуцахаар болсон бөгөөд манай компанийн зүгээс өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, шаардлагатай засвар, үйлчилгээг цаг хугацаанд нь хийлгэж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

**Төмөр зам:** Газрын тос боловсруулах үйлдвэрийг Сайншанд хоттой холбосон төмөр замын “тээвэрлэлт, арчлалт, хамгаалалтын гэрээт ажлын гүйцэтгэгч”-ээр “МТЛ” ХХК ажиллаж байгаа бөгөөд тус компани нь галт тэрэгний хөдөлгөөний байнгын бэлэн байдлыг хангаж, шаардлагатай засвар үйлчилгээний ажлуудыг хийж байна.

#### **Үйлдвэрийн цахилгаан хангамж:**

Түүхий ус хангамжийн системийн цахилгаан хангамж - ГТБҮ-ийн түүхий усны хэрэглээ цагт 378 м.куб бөгөөд үүнийг хангахын тулд үйлдвэрийн талбайгаас зүүн хойд зүгт 40 гаруй км зайд орших “Бор хөөврийн говь” газрын гүний нөөцөөс нийт 11 худаг, 1 өргөх станц бүхий ус дамжуулах хоолой бүхий системийг БНЭУ-ын “Жэй Эм Си Прожект Индиа” компани гүйцэтгэж байна. Уг системийн цахилгаан хангамжийг үйлдвэрийн талбайд байрлах “Ширээт” дэд станцаас хангах бөгөөд өргөх станц хүртэл 35 кВ, 10 кВ-ын ЦДАШ, “Ширээт” дэд станц дээр 10/35 кВ-ын 2500кВА хүчин чадал бүхий өсгөх трансформаторийн станц, өргөх станц дээрх 35/10кВ-ын 2500кВА хүчин чадал бүхий бууруулах трансформатор зэрэг цахилгааны ажлууд хийгдэж дууссан. Эрчим хүчиний үндэсний төвөөс техникийн нөхцөл гаргуулсан.

Үйлдвэрийн талбайн 8 ширхэг бага оврын дэд станцууд - ГТБҮ-ийн ИХАБҮ-ын (ЕРС-01) №1-ийн ерөнхий гүйцэтгэгчийн ажлын даалгаварт орсон ИХАБҮ-ын багц №2, №3 ба №4-ийн (Технологийн байгууламжууд) ерөнхий гүйцэтгэгчийн барилга угсралтын үеийн цахилгаан хангамжид зориулж 10/0.4 кВ-ын бага оврын дэд станцуудыг “Ширээт” дэд станцын 10кВ-ын хуваарилах байгууламжийн 4 ширхэг гаргалгаагаар тэжээхээр төлөвлөж гүйцэтгэл хийгдэж дууссан. “Ширээт” дэд станцын 10кВ-ын хуваарилах байгууламжуудын гаргалгаанууд нь 40/5А хүчин чадалтай гүйдлийн трансформаторийн байсныг 200/5А хүчин чадалтай гүйдлийн трансформатор болгон сольж, реле хамгаалалтын тусламжтай дэд станцын трансформаторын ачааллыг хэтрүүлэхгүйгээр өөрчлөлт оруулсан бөгөөд санхүүжилтыг ИХАБҮ багцын ерөнхий гүйцэтгэгч “Жэй Эм Си Прожект Индиа” компани, гүйцэтгэгчээр “ЦДУС” ТӨХК ажиллав.

“Ширээт” дэд станцын өргөтгөл - “Ширээт” дэд станцыг 110/35/10 кВ-ын 31.5 МВА хүчин чадал бүхий хос трансформаторийн болгон 110 кВ-ын хос ЦДАШ-тай болгон өргөтгөхөөр төлөвлөж байна. Шадар сайдын ажлын хэсгийн хүрээнд ЭХЯ-д энэхүү ажлын талаар албан бичгээр мэдэгдсэн. ЭХЯ-ны зүгээс өргөтгөлийн ажлын зургийг “Баясалтөгс” ХХК сонгон хийлгэж гүйцэтгүүлсэн. Уг зургийг хийхдээ манай компанийн зөвшилцэж санал авсан.

Ажлын даалгаварт ирээдүйд өргөтгөсөн “Ширээт” дэд станцын 10кВ-ын хуваарилах байгууламжаас Үйлдвэрийн дулааны цахилгаан станцын 10кВ-ын хуваарилах байгууламжтай холбох 10кВ-ын кабель шугам, холболт гүйцэтгэлийн хэсэг ороогүй байна. Үйлдвэрийн цахилгаан станцын ажлын зурагтай уялдаж хийгдэнэ.

ГТБҮ-ийн түүхий тос дамжуулах хоолой - Түүхий тос дамжуулах хоолойн толгой станц, дундын халаах өргөх станцууд болон хүлээн авах станцын цахилгаан хангамжийг ЭХЯ болон ДҮТ ТӨХХК-тай зөвшилцсөний эцэст цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг гаргуулсан. Үүнд:


- Тосон-Уул XIX талбайн дэд станцаас Толгой станц,
- Баруун-Урд дэд станцаас Халаах, өргөх 1, 2 болон 3 станцууд,
- Ширээт дэд станцаас Халаах, өргөх станц 4 болон хүлээн авах станцуудын цахилгаан хэрэглээг хангахаар төлөвлөсөн.

Инженерчлэл, ажлын зургийн ажил хийгдэж хийгдэнэ.

#### **4. ТҮҮХИЙ ЭДИЙН ХАНГАМЖИЙН ТАЛААР**


Засгийн газрын 2021 оны 266 дугаар тогтоолоор газрын тосны хайгуулын Давст ХХХI талбайг газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахад зориулан “МГТБҮ” ТӨХХК-д олгосон бөгөөд үүнтэй холбогдуулан 2022 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд

байна. Газрын тосны хайгуулын Давст XXXI талбайд өмнө хийгдсэн хайгуул, судалгааны ажлын 439 тайлан, материалууд (8.4 GB), гурван хэмжээст чичирхийллийн судалгааны ажлын мэдээлэл (793.17 GB)-ийг Үндэсний геологийн албаны Геологийн баримтын төв архиваас, газрын тосны хайгуулын Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайнуудад буюу одоогийн Давст XXXI талбайд 1995-2009 онд хийгдсэн 2 болон 3 хэмжээст чичирхийллийн судалгааны ажлын анхдагч өгөгдөл болон боловсруулалт хийгдсэн өгөгдлүүд (3.514 TB), 57 цооногийн LAS өргөтгөлтэй каротажийн бичиглэл бүхий 302 MB хэмжээтэй файлуудыг Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)-аас тус тус цахим хэлбэрээр хуулбарлан авлаа. Зарим өгөгдөл, тайлан, материал нь дутуу, тайлангуудыг дагалдах ёстой анхдагч болон боловсруулалт хийгдсэн тоон өгөгдлүүд нь гүйцэд биш, шаардлага хангахгүй байсан тул “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-иас АМГТГ-т хүлээлтэн өгсөн нийт 89.2 GB хэмжээтэй, 2006 онд Тосон уул XIX талбайд хийгдсэн 3 хэмжээст чичирхийллийн судалгааны миграцийн боловсруулалт хийгдсэн өгөгдөл, гүний гадаргуу болон хагарлын хэсэгчилсэн тайлал, 2007 онд Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд хийгдсэн 3 хэмжээст чичирхийллийн судалгааны баруун урд хэсгийн миграцийн боловсруулалт хийгдсэн өгөгдөл, гүний гадаргуу болон хагарлын хэсэгчилсэн тайлал зэргийг хуулбарлан авсан. Дээрх хуулбарлан авсан Давст XXXI талбайд хийгдсэн геологи, геофизик, гидрогеологи, геохими, өрөмдлөг, цооногийн өгөгдлүүдээр мэдээллийн сан байгуулах ажлыг хийж байгаа бөгөөд байгууллагын серверт дараах бүтцээр байршуулж байна.



Давст XXXI талбайд хийгдсэн 2 болон 3 хэмжээст чичирхийллийн судалгааны шугам, хурдас хуримтлал, хагарлын тархац, газрын тосны боломжит хураагуурын талаар хийгдсэн судалгааны зургууд болон Монгол орны зүүн хэсгийн 1:200000 геологийн зургийг цахим хэлбэрт оруулж, растер зургуудыг тоон өгөгдөл рүү шилжүүлсэн. Мөн тус талбайд өрөмдсөн цооногуудын Аналитик шинжилгээний тайлангийн мэдээллийг Kingdom программ руу шилжүүлэх зорилгоор аналитик шинжилгээний үр дүнгийн тоон утгуудыг цахим хэлбэрт оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

2007 онд Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн хэмжээнд хийж гүйцэтгэсэн 3000 гаруй км<sup>2</sup> 3 хэмжээст чичирхийллийн судалгааны өгөгдөл нь 0.001 секундийн нарийвчлалтай бөгөөд эдгээр их хэмжээний өгөгдөл гар аргаар нэг бүрчлэн тайлал хийхэд хүн, техникийн боломж



багатай манай байгууллагын хувьд цаг хугацаа их шаардаж байна. Одоогоор хэтийн төлөвтэй байх боломжтой 2 хэсэг талбайг урьдчилсан байдлаар тодорхойлоод байна.

Давст XXXI талбайд хийгдсэн 2 болон 3 хэмжээст чичирхийллийн судалгааны боловсруулалт хийгдсэн өгөгдлийг ашиглан газрын тосны хэтийн төлөв бүхий хотгорууд, тэдгээрийн судлагдсан байдлаар тус талбайг 5 дэд талбайд хувааж, хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулга, материалыг англи хэл дээр бэлтгэсэн.

**Хөрөнгө оруулагчдыг татах чиглэлээр:** Хайгуул, судалгааны ажилд хөрөнгө оруулан хамтран ажиллах компаниудын судалгааг хийж, газрын тосны хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 19 орны 170 гаруй компанийг судалж, тэдгээрээс 19 улсын 56 компанид Давст XXXI талбайд хөрөнгө оруулалт хийж, хамтран ажиллах хүсэлтийг холбогдох танилцуулга, материалын хамт цахимаар хүргүүлсэн бөгөөд 4 компани хамтран ажиллах компани сонгох үйл ажиллагаанд оролцох хүсэлт ирүүлсэн тул Нууц үл задруулах гэрээг байгуулж, Давст XXXI талбайд хийгдсэн геологи хайгуулын ажлын тайлан материалыг танилцуулах уулзалтуудыг удаа дараа биечлэн болон цахим хэлбэрээр зохион байгуулж, “МГТБҮ ТӨХХК-ийн газрын тосны хайгуул, ашиглалтын чиглэлээр хамтран ажиллах компанийг сонгох журам”-ыг хавсралтын хамт англи хэл рүү хөрвүүлэн хүргүүлсэн хэдий ч санал хүлээн авах эцсийн өдөр дуусгавар болоход ямар ч компани санал ирүүлээгүй.

#### SHORTLIST OF OIL AND GAS COMPANIES

No	Company	No	Company
I	Australia	X	Russia
1	OMV Australia Pty Ltd	31	Lukoil
2	Cue Energy Resources Ltd	32	Gazprom Neft
3	Metgasco Limited	33	Zarubezhneft
4	Santos Limited	34	Rosneft (RN-Exploration LLC)
5	Tri-Star Petroleum	XI	India
6	Jade Gas Holdings Limited	35	Indian Oil Corporation Limited
7	Elixir Energy	36	Oil India Ltd Hindustan petroleum Corp.
8	TMK Energy Limited	XII	Japan
9	ConocoPhillips	37	JAPEX
II	The United States	38	JX Nippon Oil&Gas Exploration
10	Chevron	39	Mitsui oil exploration company limited (moeco)
11	Shell Oil Company	XIII	Thailand
12	Occidental Petroleum	40	PTTEP
13	CARLYLE	XIV	South Korea
III	Canada	41	Korea National Oil Corporation
14	Vermilion Energy	42	SK group / SK eearthon
15	Suncor Energy Inc	XV	China
16	Cenovus Energy Inc	43	Sinopec
17	Frontera Energy	44	China National Petroleum Corporation
IV	United Kingdom	45	Zhenhua Oil
18	Perenco	46	Norinco International Cooperation Ltd
19	Block Energy	47	Sino Geophysical Co., Ltd
20	Trinity Exploration & Production (UK) Limited	XVa	Hong Kong
V	Germany	48	United Energy Group
21	Wintershall Dea	49	Wisdom Wealth Resources Investment Holding Group Limited
22	H. Anger's Sohne	50	Yanchang Petroleum International Limited
23	MBH Well Services	XVI	Switzerland
VI	France	52	Manas Petroleum

24	Total S.E.	XVII	Austria
25	Maurel & Prom	51	OMV Group
VII	Norway	XVIII	Serbia
26	Equinor	52	NIS Group
27	InterOil Exploration and Production	XIX	Mongolia
VIII	Italy	53	Euro Khan LLC
28	Eni	54	Terra Explorers Limited Mongolia LLC
IX	Sweden	56	Petro Matad Limited
29	МАНА Energy		
30	Tethys Oil		

Иймд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх боломжтой гэж үзсэн компаниудтай шууд гэрээ байгуулах талаар хэлэлцээ хийх зорилгоор дээрх журамд “Хамтран ажиллах санал ирээгүйгээс шалтгаалж сонгон шалгаруулалт амжилтгүй болсон тохиолдолд “МГТБҮ” ТӨХХК нь газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах чадавхитай компаниудтай шууд хэлэлцээ хийж, гэрээний нөхцөлийг тохиролцож болно” гэсэн нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

Улмаар Монгол улсад газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж буй “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-иас Давст ХХХI талбайд хамтран ажиллах санал ирүүлсэн бөгөөд манай байгууллагатай хамтран газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийхэд толгой компани болох “Дачин Ойлфийлд” болон “Хятадын газрын тосны үндэсний корпораци”-ийн шийдвэр хэрэгтэй болохыг мэдэгдсэн тул УУХҮЯ болон ГХЯ-д хүсэлтийг уламжилсан. Үүний үр дүнд Монгол улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдаар дамжуулан БНХАУ-ын Газрын тосны үндэсний корпорацад уг асуудлаар 2022 оны А-548/2022 тоот ноот бичгийг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн толгой компани болох “Дачин Ойлфийлд” компанийд илгээгээд байна.

Мөн МҮ-ын Ерөнхийлөгчийн ОХУ-д хийсэн айлчлалын үеэр “МГТБҮ” ТӨХХК болон ОХУ-ын “Зарубежгеология” ХК-ийн хооронд газрын тосны хайгуулын Давст ХХХI талбайд хайгуул, судалгаа, орд ашиглалтын чиглэлээр хамтран ажиллах тухай санамж бичгийг байгуулсан. Үг санамж бичгийн хүрээнд хийгдэх ажлууд, санхүүжилтийн хэлбэрийг тодорхой болгох талаар УУХҮЯ-аас “Зарубежгеология” ХК-д албан бичиг хүргүүлсэнээс гадна цахим уулзалтыг зохион байгуулсан бөгөөд санал болгож буй үнийн санал хэт өндөр байсан тул, үнэлгээнд хамруулах талбайн хэмжээг (Давст ХХХI талбайн 3-р дэд блокт) бууруулж, дахин уг асуудлаар яриа хэлэлцээ хийсэн ч одоогоор ямар нэгэн шийдвэртэй хариу ирүүлээгүй байна.



Хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах ажлын хүрээнд Давст ХХХI талбайд хамтран ажиллах сонирхол бүхий олон улсад болон Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг байгууллага, компанийн удирдлага, төлөөлөлтэй санал, солилцлох, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх боломжийг эрэлхийлэх уулзалтуудыг зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал:

Монгол улсад суугаа 13-н Элчин сайдын яамдад албан бичиг хүргүүлсэн бөгөөд энэ ажлын хүрээнд:

- АНУ-ын Элчин сайдын яамны Эдийн засаг, худалдааны хэлтсийн дарга Жон Чен тэргүүтэй төлөөлөгчид манай компанид зочлон газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл болон газрын тосны хайгуулын төсөлтэй танилцаж, цаашдын хамтын ажиллагааны боломжуудыг ярилцаж, хайгуулын төслийн талаар АНУ-ын сонирхсон хувийн хэвшлийн компаниудад шууд болон арилжаа, сурталчилгааны сүлжээгээр дамжуулан уламжилж, төлөөлөн ажиллах боломжтойг илэрхийлсэн.
- ИБУИНВУ-аас Монгол улсад суугаа Элчин сайдын яамны зүгээс Давст XXXI талбайн танилцуулгыг Их Британи болон Монгол улсад газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниудад уламжилж өгөхөө мэдэгдсэн.
- ХБНГУ-аас Монгол улсад суугаа Элчин сайдын яамны зүгээс Герман-Монголын бизнес эрхлэгчдийн холбоотой холбогдохыг санал болгосон. Үүний дагуу тус холбоонд газрын тосны хайгуулын төслийн талаарх танилцуулгыг хүргүүлэхэд 2022.04.19-нд бидэнтэй эргэн холбогдож тус холбооны бизнес эрхлэгчдийн уулзалтын үеэр газрын тосны хайгуулын төслөө танилцуулах боломжтойг мэдэгдсэн.

Хатуу ашигт малтмал болон худгийн өрөмдлөгийн “Элгэн дриллинг” ХХК болон геофизикийн судалгаа, зөвлөх үйлчилгээний “GE and S” ХХК-иудаас тавьсан хүсэлтийн дагуу уулзалт зохион байгуулж, эдгээр компаниудын техник тоног төхөөрөмж, үйл ажиллагааны талаарх мэдээлэлтэй танилцсан.

Газрын тосны гүний өрөмдлөгийн үйл ажиллагаа явуулдаг ХБНГУ-ын Anger's Sohne компанийн удирдлагуудтай цахим уулзалт зохион байгуулж, тус компанийн газрын тосны өрөмдлөгийн салбарт явуулдаг үйл ажиллагаатай нь танилцав.

“Евро Хан” ХХК-иас тавьсан хүсэлтийн дагуу тус компанийн үйл ажиллагаа хариуцсан захирал Д.Нандинбаяр, борлуулалт болон бизнес хөгжүүлэлт хариуцсан захирал Б.Хангальсайхан нар Герман улсын “BAUER Maschinen” компанийн “RB-T 135” маркын машинд суурилсан өрөмдлөгийн төхөөрөмж түүний хүчин чадлын талаар танилцуулах уулзалтыг хийсэн.

Австрали улсын газрын тосны зөвлөх үйлчилгээний Molyneaux Advisors компанийн гүйцэтгэх захирал Simon Molyneaux, газрын тосны инженер Steven Lee нартай цахим уулзалт зохион байгуулж, газрын тосны хайгуулын Давст XXXI талбайд хөрөнгө оруулалт татах талаар зөвлөгөө авч ажилласан. Тус компаниас Давст XXXI талбайн дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэх, компанийн дотоод сүлжээн дэх компаниудад болон олон улсад зохион байгуулагдах үзэсгэлэн, хурал, зөвлөгөөнд танилцуулах, гэрээний хэлэлцээ байгуулахад зөвлөгөө өгөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх саналыг үнийн хамт ирүүлээд байна.

БНСУ-ын Газрын тосны чанар, хангамжийн газар (К-Петро)-ын Монгол улс дахь төслийн удирдагч Шин Ги Ху тэргүүтэй төлөөлөгчид 2022 оны 5 дугаар сарын 12, 11 дүгээр сарын 18-ны өдрүүдэд манай компанитай уулзалт зохион байгуулж, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөлтэй танилцсан бөгөөд цаашид бидэнтэй хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн. Уулзалтын үеэр ярилцаж тохиролцсон хамтын ажиллагааны саналаа бид 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 01/538 тоот албан бичгээр тус байгууллагад хүргүүлсэн бөгөөд уг саналуудыг төрийн захиргааны байгууллагаар дамжуулан БНСУ-аас Монгол улсад суугаа Элчин Сайдын яаманд уламжлахыг зөвлөсөний дагуу БНСУ-ын Газрын тосны чанар, хангамжийн газар (К-Петро)-ын Монгол улс дахь төслийн удирдагч Шин Ги Ху илгээсэн хамтран ажиллах саналыг БНСУ-ын Монгол улсад суугаа Элчин Сайдын яаманд уламжлан өгөх хүсэлтийг АМГТГ-т хүргүүлсэн.



## 5. ГАЗРЫН ТОС ДАМЖУУЛАХ ХООЛОЙ БАРИХ ТӨСЛИЙН ТАЛААР

УУХҮЯ-аас 2021 оны 4 дүгээр сард олон улсад нээлттэй зарласан "Монгол улсад газрын тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж, барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах" тендерт БНХАУ-ын "Norinco International Cooperation Limited" компани шалгарсан бөгөөд тус компани нь дамжуулах хоолойн бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтын 90 хувьтай тэнцэх зардлын эргэн төлөлтийг зээлийн хүү, шимтгэлгүй, Засгийн газрын баталгаа шаардахгүйгээр барилга угсралтын 3 жилийн хугацаанд Монголоос худалдан авах нүүрсний борлуулалтын орлогоор төлөх, төслийн хөрөнгө оруулалтын 10 хувьтай тэнцэх зардлыг олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх жишгийн дагуу захиалагч тал буюу Монгол Улсын Засгийн газраар урьдчилан телүүлэх санал ирүүлсэн.

Хэлэлцээрийн явцад олон асуудал шийдвэрлэсний дотор Захиалагч талаас шууд төлбөр хийлгэхээр санал болгосон 38.0 орчим сая ам.долларыг нүүрсээр төлөхөөр тохиролцож, төслийн санхүүжилтийг 100 хувь "Norinco International Cooperation Limited" компани хариуцах асуудлыг шийдвэрлэсэн.

Уг асуудлыг УУХҮЯ, "Эрдэнэс Тавантолгой" ХК, "МГТБУ" ТӨХХК-иуд урьдчилсан байдлаар хэлэлцэж, Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, шаардагдах хөрөнгө оруулалт болох 397.0 сая ам.долларыг нүүрс урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэхийг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн ТУЗ-д даалгасан. Ингэснээр талууд дараах гэрээ хэлцлүүдийг хийж, бүтээн байгуулалт эхлэх нөхцөл бүрдсэн.

- Төслийн захиалагч УУХҮЯ, төслийн санхүүжүүлэгч "Эрдэнэс Тавантолгой" ХК, төсөл хэрэгжүүлэгч "МГТБУ" ТӨХХК болон төслийн гүйцэтгэгч БНХАУ-ын төрийн өмчит "Norinco International Cooperation Limited" компаниудын хооронд 2022.04.18-ны өдөр Хамтран ажиллах гэрээ байгуулсан.
- "МГТБУ" ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022.04.21-ний өдрийн 5 дугаар тогтоолоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-тай гэрээ байгуулж, их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрсөн.
- "МГТБУ" ТӨХХК болон "Norinco International Cooperation Limited" компанийн хооронд 2022.04.21-ний өдрийн MR-01/2022 дугаартай Газрын тос дамжуулах хоолойн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх (EPC) гэрээ байгуулсан.
- "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн ТУЗ-ийн 2022.04.22-ны өдрийн 23 дугаар тогтоолоор их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрсөн.
- "МГТБУ" ТӨХХК болон "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хооронд 2022.04.22-ны өдрийн ЭТТ-2022/252, 09/22 дугаартай Газрын тос дамжуулах хоолойн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн гэрээ байгуулсан.
- "Эрдэнэс Тавантолгой" ХК болон "Norinco International Cooperation Limited" компанийн хооронд 2022.04.22-ны өдөр Нүүрс худалдах, худалдан авах гэрээ байгуулсан.

"Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралт"-ын EPC гэрээний давуу талууд:

- ✓ Нүүрсээр төлбөр хийх
- ✓ Урьдчилгаа төлбөр шаардахгүй
- ✓ ЗГ-ын баталгаа шаардахгүй
- ✓ Зээлийн хүү, шимтгэлгүй
- ✓ ЗГ-н өрийн хязгаарт нөлөөлөхгүй
- ✓ Улсын төсөвт хүндэрлэхгүй

Улмаар Norinco International Cooperation Limited" компанитай "Ажил эхлүүлэх уулзалт"-ыг хийсэн бөгөөд тус компанийн зүгээс Ковид-19 цар тахлын эсрэг БНХАУ-аас хэрэгжүүлж байгаа хориг, хатуу арга хэмжээний улмаас барилга угсралтын ажлыг эхлүүлэхэд хүндрэлтэй байсан хэдий ч туслан гүйцэтгэгч компаниудыг сонгон шалгаруулах тендериин ажлыг зохион байгуулж, Дамжуулах хоолойн инженер геодези, геотехникийн ажлын хүрээнд, байр зүйн зураглалын мэдээлэл боловсруулалт, хөрсний дээжийн судалгааны

ажлуудыг гүйцэтгэж байна. Үүнээс гадна халаах-өргөх станцын 6 байршилд ажилчдын түр байр (кемп)-ны барилга угсралтын ажил үргэлжлэн явагдаж байна.

Манай компанийн зүгээс барилга угсралтын EPC гэрээнд туссан захиалагчийн хүлээсэн үүрэг буюу хоолойн трасс, насос станцуудын газрын гэрчилгээ, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлүүд авах болон ажлын явц, төлөвлөгөө, гүйцэтгэлд хяналт тавих, баталгаажуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэж, анхаарал хандуулах шаардлагатай асуудлуудын талаар санал солилцох техникийн уулзалтууд, сарын ажлын явцын хурлуудыг тогтмол хийж байна.

Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хэрэгжүүлж буй Нуурсээр барагдуулах (Оффтэйк) нөхцөлтэй гэрээний хэрэгжилтийг 2022 оныг дуустал хойшлуулах Засгийн газрын шийдвэр 2022.09.22-ны өдөр гарсантай холбоотойгоор “Норинко интернэйшнл Кооперейшн” компанийн нүүрс ачилтыг хэд хэдэн удаа зогсоосоны улмаас хуваарийн дагуу нүүрс ачилтыг гүйцэтгэж чадаагүй. Нуурсний ачилтыг saatuuлах нь дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийг хойшлуулах эрдэлтэй тухай, талууд гэрээний үүргээ биелүүлж ажиллахыг “Норинко интернэйшнл Кооперейшн” компаниас мэдэгдсэн. “Нүүрс худалдах, худалдан авах гэрээ”-ний дагуу 2022 онд 461 мянган тонн нүүрс ачих хуваарьтай байснаас дээрх шалтгааны улмаас 154 мянган тонн нүүрс ачилт хийгдсэн байна.

#### **Ажлын явц:**

№	Ажил	Хийгдсэн, хийгдэж буй ажил	Нийт ажлын явц
1	Гэрээ хэлцэл	✓ “Memorandum of agreement” ✓ “Хамтын ажиллагааны гэрээ” ✓ “ЕРС гэрээ” ✓ “Санхүүжилтийн гэрээ” ✓ “Нүүрс худалдаж, худалдан авах гэрээ”	100%
2	Бэлтгэл ажил	✓ Ажил эхлүүлэх уулзалт ✓ Техникийн нөхцөл ✓ Ажил эхлүүлэх зөвшөөрөл ✓ Техникийн уулзалт	92%
3	Газар ашиглалт	✓ Трассын дагуух газар ✓ Насос станцуудын газар	90%
4	Инженерийн суурь судалгаа	✓ Байр зүйн зураглал ✓ Инженер геодези, геотехник	90%
5	Түүхий тосны шинжилгээ	Урсац, шинж чанарын шинжилгээ (Wax Differential scanning calorimetry)	100%
6	Техникийн зураг төсөл	Загвар зураг болон Техникийн зураг төслийг хийж гүйцэтгэж байна.	30%
7	Түр кемп	6 станцын байрлалд тус бүр 8-10 барилгатай, 2 давхар хашаа хайс, дотор угаалгын өрөө, халуун хүйтэн устай, төмөр бетон суурь, төмөр каркас сэндвичэн барилгын хийцтэй, бетон зам талбай бүхий түр кемпийн барилга угсралтын ажил хийгдэж байна.	32%

8	Технологийн зам барих	Трассын дагуу 530 км шимт хөрс хуулалтыг хөрс хөлдөлтийн байдлаас хамаар 8 см орчим гүнтэй хийсэн.	9%
9	Байгаль орчин	✓ Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ ✓ Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ ✓ Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	60%
10	Цэвэр ус хангамж	Барилга угсралт болон үйл ажиллагааны үеийн цэвэр усны 6 худагнаас 3-ийг гаргасан (380м гүн)	50%

Манай компанийн зүгээс дамжуулах хоолойн тээврийн систем барьж байгуулах ажлыг Төслийн менежментийн зөвлөхгүй тендерийн бичиг баримт боловсруулах, гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороонд техникийн туслалцаа үзүүлэх, 4 терлийн гэрээний төслийг бэлтгэх, ажил эхлүүлэх уулзалт хийх, гүйцэтгэгчээс ирүүлсэн техникийн бичиг баримтуудыг (Plan, Procedure, Specification, Scheme) хянах, дамжуулах хоолойн системийн төлөвлөлт, инженерчлэлийн ажилд захиалагчийн хүсэл, эрх ашгийг тусгах, сар болгоны ажлын явцын хурлыг зохион байгуулах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих зэрэг “Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ЕРС гэрээ”-ний захиалагч талаас хүлээлсэн үүргийг болон Төслийн менежментийн зөвлөх компанийн хариуцах бүхий л үүрэг, хийх ажлуудыг амжилттай гүйцэтгэн ажиллаж байна.



## 6. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Газрын тос боловсруулах үйлдвэр, хотхон болон ус дамжуулах хоолой зэрэг төслийн бүтээн байгуулалтын ажлын талбайд зөвлөх болон ерөнхий гүйцэтгэгч байгууллагын үйл ажиллагаанд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр хяналт тавин ажиллаж байна. Үүнд:

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр дүрэм журам боловсруулах ажлын хурээнд:

Газрын тос боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглах “Үйлдвэрийн аюулгүй ажиллагааны гарын авлагага”-ыг Англи хэлнээс орчуулж, Монгол Улсын хууль, дүрэм журамд нийцүүлэх, боловсронгуй болгох ажил хийгдэж байна.

Үйлдвэрийн барилгын ажлын явцад гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, барилгын ажлын талбай түүний гаднах эрсдэл бүхий орчны аюулгүй байдлыг бүрдүүлэх, хяналт тавих, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартын шаардлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор гүйцэтгэх захирлын 2022 оны А/36 дугаар тушаалаар “Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах

хэрэгслийг олгох, ашиглах журам”, А/94 дүгээр тушаалаар “Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын үед барилгын ажлын талбайд мөрдөх аюулгүй ажиллагааны журам”-ыг тус тус батлуулан, мөрдөн ажиллаж байна.

*Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр өдөр тутам авч хэрэгжүүлж буй ажлын хүрээнд:*

Компанийн ажилтнууд тээврийн хэрэгслээр хот, орон нутаг, үйлдвэр орчимд зорчиход аюулгүй ажиллагааг хангах үүднээс “Тээврийн хэрэгслээр зорчих үеийн аюулгүй ажиллагааны журам”-ын хүрээнд тогтмол аюулгүйн зааварчилгаа өгч байгаа бөгөөд компанийд шинээр орсон ажилчдад “Компанийн оффисын ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа”-г өгч, ажлаас гэр хүртэлх маршрутыг тогтоон баталгаажуулж байна.

Үйлдвэрийн барилгын ажлыг гүйцэтгэж буй ерөнхий гүйцэтгэгч “Жэй Эм Си Прожект Индия” компани болон туслан гүйцэтгэгч компаниудын ХАБЭА-н талаар авч хэрэгжүүлж буй ажлын тайланг тогтмол авч, өдөр тутмын хяналт тавьж зөрчил дутагдуудыг арилгуулах арга хэмжээ авч ажилласан.



2022.10.28-ны өдөр газрын тосны үйлдвэрийн хотхоны талбайгаас сум хэлбэртэй тэсрэх зүйл олдсон бөгөөд тухайн ажил хийгдэж байсан талбайг тусгаарлан ажлыг түр зогсоох арга хэмжээ авч Дорноговь аймгийн цэргийн штабт нэн даруй мэдэгдсэн. Цэргийн штабын зүгээс яаралтай арга хэмжээ авч ЗХЖШ-аас саперын бүлэг томилон 2022.11.02-ны өдөр тэсрэх зүйлсийг устгаж аюулгүй болгосон.

Газрын тосны үйлдвэрийн хотхоны талбайд 2021 оноос хойш хэд хэдэн удаа тэсэрх дэлбэрэх зүйлс илэрч, тухай бүр аюулгүй болгох ажлыг зохион байгуулж ирсэн бөгөөд цаашид тохиолдож болох аюул эрсдлээс урьчилан сэргийлэх зорилгоор үйлдвэрийн хотхон, түүний ойр орчимд тэсрэх зүйлс эрэн хайх ажлыг зохион байгуулах хүсэлтийг Дорноговь аймгийн Засаг даргад уламжилсан. Уг ажлыг Дорноговь аймгийн Цэргийн штаб зохион байгуулахаар болсон.

*Байгаль орчны чиглэлээр хийсэн ажлууд:*

2021 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан”, 2022 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулан БОАЖЯ-нд хүргүүлж, батлуулсан.

“Эко бизнес – Эко ажлын байр” уриан дор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дорноговь аймагт “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, уул-урхайн ашиглалт болон боловсруулах баяжуулах үйлдвэртэй байгуулах “Батламж гэрээ”-г байгуулсан.

Газрын тос дамжуулах шугам хоолойн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг БОАЖЯ-аар гаргуулж, нарийвчилсан үнэлгээ хийгдэж байна.

Үйлдвэрийн төмөр зам орчимд жил бүрийн өвөл цагаан зээрийн сүрэг нүүдэллэн ирж, төмөр замын хориг хашаанд олноор үрэгдэх тохиолдол гарч байна. Уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар Дорноговь аймгийн холбогдох төрийн байгууллага болон төрийн бус


байгууллагуудтай удаа дараа зөвлөлдөж, БОАЖГ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу ЗТХЯ-аас төмөр замын хориг хашааны бүтцийг өөрчилж болох эсэх талаар чиглэл авч, газрын тос боловсруулах үйлдвэрийн төмөр замын хориг хашааны бүтцийг өөрчилж, цагаан зээрийн сүрэг нүүдэллэх замыг нээсэн.

## 7. ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ЧИГЛЭЛЭЭР:

МГТБҮ ТӨХХК нь газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн хэрэгжилт, үйлдвэрийн хотхоны бүтээн байгуулалтын ажлын явц, үйлдвэр байгуулагдсанаар нийгэм, эдийн засагт гарах үр нөлөөг олон нийтэд таниулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Цахим орчин дахь мэдээллийн урсгалыг сайжруулахын тулд Фейсбүүк, Твиттер, Youtube, Linkedin платформуудыг идэвхтэй ашиглаж тухайн платформуудад компанийн албан ёсны аккаунт буюу хаягуудыг үүсгэж, мэдээ мэдээллийг цаг тухай бүрд нь шинэчлэн оруулж 06 дугаар сарын байдлаар Фейсбүүк хуудас 5000, пейж 8818 Твиттер хуудас 481 дагагчтай байна. [www.zindaa.mn](http://www.zindaa.mn), [www.ikon.mn](http://www.ikon.mn), [www.gogo.mn](http://www.gogo.mn), [www.nuuts.mn](http://www.nuuts.mn), [www.mongolianminingjournal.mn](http://www.mongolianminingjournal.mn), [www.mmhi.mn](http://www.mmhi.mn), [www.elive.mn](http://www.elive.mn), [www.montsame.mn](http://www.montsame.mn), [www.ulsturch.mn](http://www.ulsturch.mn), "Mongolian Mining Journal" монгол хэлээр, MNB Цагийн хүрд, MNB Долоо хоногийн тоймд үйлдвэрийн бүтээн байгуулалтын болсон үйл явдлуудтай холбоотой мэдээ мэдээллийг бэлтгэн компанийн албан ёсны вэбсайт, фейсбүүк, твиттер хуудсанд нийт 96 удаа хэвлэл мэдээллийн материал пост бэлдэж өгсөн.

- ТВ-ийн мэдээ, нэвтрүүлэг: 4 удаа
- Нэвтрүүлэг: 1 удаа
- Сонин, сэтгүүлийн мэдээ, ярилцлага: 3 удаа
- Сайтын мэдээ, нийтлэл: 19 удаа цацагдсан болно.
- Фейсбүүк, Твиттер, Youtube-пост болон видео контент

Компанийн үйл ажиллагаатай холбоотой үйл явдлыг цаг алдалгүй сурвалжлага хийж иргэд, олон нийтэд хүргэж байгаа бөгөөд 2022 онд [www.mongolrefinery.mn](http://www.mongolrefinery.mn) вэбсайтад 52858 гаруй хүн хандсан тоон үзүүлэлттэй байна.



ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН  
ТЕХНОЛОГИЙН БАЙГУУЛАМЖУУДЫГ АНУ, БАРУУН  
ЕВРОПЫН ТОМООХОН КОМПАНИУДЫН ЛИЦЕНЗЭЭР  
БАЙГУУЛНА

Гәрәп төр белгисизлүү түзүлүштөрдөн бар  
жарыс проявился учительчак оркандың мөнөхөн  
үйрөн-мөнөхөн проявился Устунарчык  
жана көмүк анында шалшулуктардын  
чыгарылыштарынан көзөн «Көмүк-  
Төмөнкүс» сөзлөрүн жана 30 түрдүү  
жана салбарттардын жана «Көмүк-  
Төмөнкүс» сөздөрүнен башталған дәлелдердөн  
жарыс. Нес бейнелгилүү жана берилген  
мөнөхөн түзүлүштөрдөн көзөн Түрк мөнөхөн  
Балкынордуктагы дарын тасалып көзөн ГТБУ-  
нын Устунарчык түзүлүштөрдөн шалшулуктардын  
барынан.

Жаннатың Тәмәннегің шеңберінен на 30 парын  
әрі алғашкы, оның тарихтың ғалымдарының  
шешімінде жазылған жаңа жаңа жаңа  
шешімдер төс жасағылған күннен салғындың Тәмәннегін  
таптағандағы мәнін анықтады.



Айнан да Бөлжүлгүүдөн тарабарлыкташында 4-бүрткүүчтөн Болот Гедәрханын  
тапшырылышын көрсөтүү шартынан шайланыптуу болгондуктан кийинде  
Башкенттеги түштүрүлүштөрдөн болжумдуулганында  
Башкортостандын азаттык мөрөнүн түштүрүлүштөрдөн болжумдуулганында  
Башкортостандын азаттык мөрөнүн түштүрүлүштөрдөн болжумдуулганында  
Башкортостандын азаттык мөрөнүн түштүрүлүштөрдөн болжумдуулганында

Indoor air quality - Residential

то виноградную лягушку на про-  
тестостероне.  
Изменение вида, или генетика, на-  
блюдалось у всех изученных  
видов. Уже в первом поколении  
гусенического возраста начали отмечаться  
различия. Часто гусеницы были раз-  
личимы физически: голова и переднегрудка  
различались по цвету и формам. Гусеницы  
имели различные окраски: зеленые, оранжевые  
или коричневые. Некоторые виды  
зародышей имели ярко-красные  
булавообразные кончики кишечника, другие же  
имели пурпурные кончики.



МГТБУ ТӨХХК-ийн удирдлагууд газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн явц, тулгамдсан асуудлууд болон төр засгийн зүгээс яаралтай шийдвэрлэх шаардлагатай асуудлуудын талаар Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Шадар сайд С.Амарсайхан, УҮХҮ-ийн сайд нарт тухай бур танилцуулж ажилласан.

Мөн БНЭУ-аас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд М.П.Сингхтэй төслийн ажилд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар тогтмол уулзалт ярилцлага хийж байна.



“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн ерөнхийлөгч Жү Да Ли тэргүүтэй төлөөлөгчид “МГТБҮ” ТӨХХК-д зочилж, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн үйл явц, компанийн үйл ажиллагаатай танилцлаа. Тус компанийн зүгээс газрын тосны олборлолтын өнөөгийн байдал, цаашдын боломжийг танилцуулж, үйлдвэрийг түүхий тосоор найдвартай хангахын тулд хайгуулын ажлаа өргөжүүлэх талаар монголын төр засаг, манай компанийтай хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.



АНУ-ын Элчин сайдын яамны Нэгдүгээр нарийн бичгийн дарга бөгөөд Эдийн засаг, худалдааны албаны дарга Жон Чен, Худалдааны ахлах мэргэжилтэн Майкл Ричмонд нар 2022.04.13-ны өдөр “МГТБҮ” ТӨХХК-д зочилж, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн үйл явцтай танилцлаа. Цаашид газрын тосны хайгуул, ашиглалтын салбарт хамтран ажиллах боломж, боловсон хүчин бэлтгэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх асуудлуудаар талууд санал солилцсон.

БНСУ-ын Элчин сайд Ли Ё Хун тэргүүтэй төлөөлөгчид Дорноговь аймаг дахь үйлдвэрийн талбайд очиж, бүтээн байгуулалтын ажилтай танилцсан. Мөн БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (KOICA), БНСУ-ын Газрын тосны чанар, түгээлтийн агентлаг (K Petro)-аас манай улсад 2022-2025 оны хооронд хэрэгжүүлж буй “Монгол улсын агаарын чанарыг сайжруулах хүрээнд эрчим хүчний эх үүсвэрийн чанарын тогтолцоо, чадавхыг бэхжүүлэх” төслийн удирдагч Шин Ки Ху, Газрын тосны шинжээч Кан Ки Сан нар “МГТБҮ” ТӨХХК-ийн үйл ажиллагаа, төслийн явцтай танилцлаа. Уулзалтын үеэр лабораторийн тоног төхөөрөмж болон үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө өгөх, лабораторийн ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллах санал тавьж, Газрын тосны хайгуулын төслийн талаар БНСУ-ын SK Group-т уламжилж өгөх боломжтой гэдгийг мэдэгдсэн.

БНЭУ-ын Гадаад хэргийн яамны Засгийн газрын төслүүд хариуцсан нарийн бичгийн дарга тэргүүтэй төлөөллүүд Шадар сайд, УУХҮ-ийн сайд, ЭЗХ-ийн сайд болон бусад төр засгийн удирдлагуудтай албан уулзалтууд хийв.



Монгол Улсын Засгийн газар, НЭДТГ, MYXAYT, НҮБ-аас хамтран зохион байгуулсан “Тогтвортой хөгжлийн зорилго” нээлттэй өдөрлөгт оролцож, төслийн талаар танилцуулга хийсэн.



## 8. БУСАД ХИЙГДСЭН АЖЛУУД:

“МБГТҮ” ТӨХХК нь 2022 онд холбогдох дээд шатны байгууллага болон бусад харилцагч байгууллагуудад 563, гадны харилцагч байгууллагуудад 88 албан бичиг тус тус хүргүүлж ажилласан бол дээд газраас 132, бусад газраас 171 албан бичиг хүлээн авч, компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр Гүйцэтгэх захирлын А тушаал 107, хүний нөөц, түүнтэй холбогдолтой 93 тушаал гарч, хэрэгжилтийг ханган ажилласан.

Компанийн хэмжээнд байгууллагын архивын баримтыг бүрдүүлэх, бүртгэх, нягтлан шалгалт хийх, хадгалах, хамгаалах, төрийн болон албаны нууц, байгууллагын нууцын хадгалалт, хамгаалалтын ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд байгууллагын архивын бүртгэлд газар, хэлтэс, албадаас ирүүлсэн 7 нэр төрлийн 5,87GB, 645,1MB хэмжээтэй 7ш CD тус тус бүртгэлд авч, 208 хадгаламжийн нэгж үүсгэлээ.

“МГБТУ” ТӨХХК-ийн ТҮЗ-ийн 2021 оны 23 дугаар тогтоолоор компанийн зохион байгуулалтын бүтцийг 6 газар, 8 хэлтэс, 5 албатай, орон тооны дээд хязгаарыг 151 хүнээр байхаар шинэчлэн баталсаны дагуу 2022 онд 84 үндсэн ажилтан, 3 гэрээт ажилтантайгаар үйл ажиллагаагаа явууллаа. Мөн үйлдвэрийн хотхоны бүтээн байгуулалтын талбарт хяналтын 4 инженер гэрээгээр ажил гүйцэтгэлээ.

Шинэчлэн найруулсан Хөдөлмөрийн тухай хууль хэрэгжилтийг хангуйж, Гүйцэтгэх захирлын 2022 оны А/01 дүгээр тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Компанийн зүгээс ажилтан, албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд 21 ажилтныг Энэтхэг улсын “Индиан Ойл Кооперэйшн” /Indian Oil Cooperation/ компани болон Ражив Гандийн нэрэмжит Газрын тосны технологийн институт /Rajiv Gandhi Institute of Petroleum Technology/-ын хамтарсан “Газрын тос боловсруулах дэвшилтэй технологи-Advanced Petroleum Refining Technologies” сургалтын хөтөлбөрт, мэргэшлийн гэрчилгээ олгох, 16 ажилтныг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг хэрэгжүүлэх, гэрчилгээ олгох сургалтад, “Эрсдэлийн менежментийн тогтолцоо хэрэгжүүлэх сургалт”, СЭЗИС-ийн магистрын сургалтад тус бүр 1 ажилтныг хамруулж, сургалтын төлбөрийн дэмжлэг туслалцаа үзүүлж ажилласан.

Мөн газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажилд БНЭУ-аас гадна Итали, Франц, АНУ, Нидерланд, БНХАУ зэрэг улс орнуудтай хамтран ажиллах болсноор төслийн үйл ажиллагаа, цар хүрээний хувьд олон улсын шинж чанартай болж, улам өргөжин 2022 онд нийт 184 инженер, техникийн ажилтнууд ирж ажиллалаа.

Түүнчлэн компанийн зүгээс газрын тосны үйлдвэрт ажиллах инженер, техникийн ажилтнуудыг бэлтгэх, хүний нөөц бүрдүүлэх үүднээс их, дээд сургуулиудаас жил бүр зохион байгуулдаг “Ажил олгогчдын өдөрлөг”, “Үйлдвэрлэлийн Өдөрлөг”-т оролцож шинэ төгсөгчдөд үйлдвэрийн талаар холбогдох нэгжүүдийн төлөөлөлтэй хамтран танилцуулж, ажилд орох хүсэлтэй иргэдийг нөөцдө бүртгэсэн.

ШУТИС-иас зохион байгуулсан “Химиин инженерчлэлийн салбарын ба төгсөгчдөд ажил олгох байгууллагуудын төлөөлөлтэй хийх өдөрлөг”, МУИС-ийн ХШУИС-ийн Нано шинжлэх ухаан, нанотехнологийн төвөөс зохион байгуулсан “Ажлын байрны өдөрлөг”-т гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг болон холбогдох албан тушаалтнууд оролцож, төслийн тухай болон үйлдвэрт шаардлагатай ажиллах хүч, мэргэжилтнүүдийг бэлтгэх бодлогын талаар танилцууллаа. Мөн ШУТИС-ийн Эрчим хүчний сургуулийн төгсөх ангийн оюутнуудтай уулзаж, ажлын байр сурталчлах ажлыг зохион байгууллаа.

Мөн Газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулах цаг ойртож байгаа тул үйлдвэрт ажиллах 300 нарийн мэргэжлийн инженерийг 3 жилд багтаан бэлтгэхээр ШУТИС-д “Газрын тос боловсруулах үйлдвэрийн инженерчлэл”-ийн бакалаврын анги шинээр нээж, тэтгэлэгтэй хөтөлбөр зарласанаар 2022-2023 оны хичээлийн жилд 20 оюутан сонгон суралцаж байна. МУ-ын Шадар сайдын 2021 оны 87 дугаар тушаалаар баталсан Тусгайлсан хөтөлбөрийн дагуу дотоодын их, дээд сургуулиудад “Үйлдвэрт ажиллах инженер, техникийн ажиллагсдыг бэлтгэх”-д шаардлагатай санхүүжилтийн асуудлыг Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт компаниудын сургалтын урамшууллаас шийдвэрлэх” үүрэг УУХҮ-ийн сайд болон БШУ-ны сайд нарт тус тус өгөгдсөний дагуу санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Манай компанийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтаар тавьсан “130/A0150053 дугаар акт”-ын хэрэгжилтийг хангуулахын тулд манай эзэмшилийн төмөр замаар тээвэр хийсэн “Монголиан транс ложистик” (МТЛ) ХХК-тай удаа дараа уулзалт зохион байгуулж, төлбөрийг барагдуулах талаар амаар болон бичгээр шаардлага тавьсан хэдий ч “МТЛ” ХХК-ийн зүгээс “1,732,900,704.00 төгрөгийн дүн бүхий төлбөрийн үндэслэл, тооцоо болон хэмжээг хүлээн зөвшөөрөх боломжгүй” бөгөөд бидний эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндсөн захиргааны шийдвэрийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд уг актад заасан төлбөрийг төлөх үндэслэлгүй гэж мэдэгдээд байгаа болно.

Төмөр замын тариф тогтоох асуудлаар 2020 оноос эхлэн мэргэжлийн болон холбогдох байгууллагуудад удаа дараа хандсаны эцэст Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2022.11.18-ны өдрийн 03/5364 тоот албан бичгээр ирүүлсэн төмөр замын төлбөрийн тарифтай холбоотой санал, дүгнэлтийг үндэслэн Манай компани болон “МТЛ” ХХК-ийн хооронд 2022.11.18-ны өдөр “Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр чиглэлийн төмөр замыг ашиглуулах гэрээ” байгуулж, “МТЛ” ХХК нь 2022 оны төмөр зам ашигласны төлбөрийг төлж барагдуулсан.

## 9. ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

### **Хөгжлийн банкны зээлийн санхүүжилт:**

Манай компани, Хөгжлийн банк хооронд 2018 онд байгуулсан Зээлийн гэрээний дагуу 250,0 тэрбум төгрөгийн зээлийн шугам нээгдсэн бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 166,3 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг Хөгжлийн банкнаас авч үйлдвэрийн гаднах дэд бүтцийн байгууламжууд, Газрын тосны үйлдвэрийн хотхоны бүтээн байгуулалт, төсөл хэрэгжүүлэгч компанийн үйл ажиллагаанд зарцуулсан. Жилийн 11,89 хувийн хүүтэй энэхүү зээлийн хуримтлагдсан хүүгийн хэмжээ 52,9 тэрбум төгрөг болоод байна.

2022 оны 3 дугаар сараас эхлэн манай компанийн зээл, барьцаа хөрөнгийн харьцаа алдагдсан шалтгаанаар зээл олгохгүй гэж мэдэгдэж, 7 дугаар сараас зээлийн санхүүжилтийг зогсоосны улмаас урин дулаан улиралд бүтээн байгуулалтын ажил саатаж, компанийн үйл ажиллагаа доголдсон.

Улс орны эдийн засагт онцгой ач холбогдолтой төслийн санхүүжилтийн хүндрэлийг арилгах, тухайлбал, барьцаа хөрөнгө шаардахгүй болгох, зээлийн баталгаа гаргах замаар санхүүжилтийг тасралтгүй олгох, цаашилбал зээлийн хүүг бууруулах, тэглэх хүртэл асуудал төр засгийн өндөр түвшинд яригдсан боловч тодорхой арга хэмжээ авагдахгүйгээр өнөөг хүрч, 2023 оноос эхлэн төсөл хэрэгжүүлэгч компани үйл ажиллагаагаа явуулах боломжгүй нөхцөл байдал үүслээ.

Хөгжлийн банкны зээлийн санхүүжилтэд үүссэн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбарт зээлийн дахин санхүүжилтийн асуудал яригдсан бөгөөд УУХҮ-ийн дэд сайдаас өгсөн үүрэг даалгаврын дагуу БНЭУ-ын Экспорт-Импортын банкинд уг асуудлыг тавихад Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаасаа албан ёсоор хүсэлт ирүүлэх шаардлагатай гэж мэдэгдсэн юм. Үүний дагуу УУХҮЯ-нд албан бичиг хүргүүлж, Сангийн яамаар дамжуулан Энэтхэгийн талд уламжилж өгөхийг хүссэн боловч өнөөг хүртэл Энэтхэгийн Эксим банкинд манай талаас ямар нэг хүсэлт хүргүүлээгүй байна.

Шадар сайдын 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 87 дугаар тушаалаар “Хөгжлийн банкны зээлийн хүүг бууруулах, өөр эх үүсвэрээс зээлийг төлөх боломжийг судалж танилцуулах” үүрэг Сангийн сайдад өгөгдсөн билээ.

### **“Газрын тосны үйлдвэрийн хотхон”-ы II ээлжийн барилгууд:**

Манай компанийн захиалгаар, Хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт баригдаж буй “Газрын тосны үйлдвэрийн хотхон”-ы II ээлжийн барилгуудын барилга угсралтын ажлыг БХЯ өөрийн харьяа Зэвсэгт хүчний 339

дүгээр ангиар гүйцэтгүүлэхээр болж, харин 339 дүгээр анги нь З туслан гүйцэтгэгч компаниар ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан.

Хотхоны II ээлжийн барилгуудыг 2021 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн байсан хэдий ч туслан гүйцэтгэгч компаниуд нь 2021 оны 7 дугаар сараас барилгын ажлаа зогсоосон бөгөөд ажлын гүйцэтгэл 32%-тай байна. Гэрээний хугацаа 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр дууссан тул гэрээг дүгнэж, гэрээний хугацааг сунгах, талаар манай талаас тус яаманд удаа дараа мэдэгдэж, уулзалт ярилцлага зохион байгуулсан боловч өнөөдрийг хүртэл тодорхой шийдвэрт хүрээгүй байна.

Зэвсэгт хүчний 339 дүгээр анги нь Барилгын тухай хуулийн 13.4 дэх заалтыг зөрчин Захиалагч тал болох манай компанийн зөвшөөрөл, зураг төсөл, төсвийг зохиогчийн шийдвэргүйгээр их хэмжээгээр өсгөсөн үнийн дун бүхий төсвийг шинээр зохиож, Барилгын хөгжлийн төв, Төсөвчдийн нэгдсэн холбоогоор дахин батлуулсан байсан. Өөрөөр хэлбэл ажил гүйцэтгэх 21.0 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дунг 37.0 тэрбум төгрөг болгон 16.0 тэрбум төгрөгөөр өсгөхөөр төсөв батлуулсан байна.

Бид барилгын материалын үнийн өсөлттэй холбоотойгоор БХЯ-аас өгсөн чиглэлийн дагуу УИХ-ын 88 дугаар тогтоол, БХБ-ын сайдын 2022 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 75 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх барилга, байгууламжийн төсөв өргтийн (барилгын материалын үнэ) өөрчлөлтийг тооцох түр журам”-ыг баримтлан Зэвсэгт хүчний 339-р ангийн төсөвчинтэй хамтран БХЯ-ны хариуцсан барилгуудын материалын үнийн зөрүүг тооцоолоход 5.3 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байгаа юм. БХЯ-ны зүгээс уг тооцоогоор гэрээний үнийн дунг нэмэгдүүлэн, ажил үүргээ биелүүлэхийг 339 дүгээр ангийн туслан гүйцэтгэгч компаниудаас шаардсан боловч эс зөвшөөрч, 16.0 тэрбум төгрөгөөр өсгөх шаардлага тавьсан болно.

БХЯ-ны албан тушаалтнуудтай 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хийсэн уулзалтын үеэр харилцан зөвшилцэж, дээрх журмын дагуу тооцсон 5.3 орчим тэрбум төгрөгийн үнийн зөрүүг манай компаниар уламжлан, Барилгын хөгжлийн төвөөр батлуулахаар тохиролцсон боловч БХЯ-аас 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдөр гэрээний 21.0 тэрбум төгрөгийн үнийн дунг 43.0 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл 22.0 тэрбум төгрөгөөр өсгөхөөр төсөв манайд ируулсэн бөгөөд бид хууль, журмаас гадуур гэрээний үнийн дунг их хэмжээгээр нэмэгдүүлэх боломжгүй тул асуудлыг улам бүр хүндрэлтэй байдалд оруулаад байна.

#### **Үйлдвэрийн боловсон хүчин бэлтгэх талаар:**

Шадар сайдын 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 87 дугаар тушаалаар тусгайлсан хөтөлбөрийн дагуу дотоодын их, дээд сургуулиудад “Үйлдвэрт ажиллах инженер, техникийн ажиллагсдыг бэлтгэх”-д шаардлагатай санхүүжилтийн асуудлыг Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт компаниудын сургалтын урамшууллаас шийдвэрлэх” үүрэг УУХҮ-ийн сайд, Боловсрол шинжлэх ухааны сайд нарт тус тус өгөгдсөн.

Газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулах цаг ойтож, үйлдвэрт ажиллах инженер, техникийн ажиллагсдыг бэлтгэхэд хугацаа бага үлдээд байна.

Үйлдвэрт ажиллах 300 нарийн мэргэжлийн инженерийг 3 жилд багтаан бэлтгэхээр ШУТИС-д “Газрын тос боловсруулах үйлдвэрийн инженерчлэл”-ийн бакалаврын анги шинээр нээж, тэтгэлэгтэй хөтөлбөр зарласан боловч, 2022-2023 оны хичээлийн жилд 20 оюутан л тус ангийг сонгосон байна. Залуу үе байгалийн ухааны хичээлд сонирхол буурсан, үүнтэй холбоотойгоор инженерийн чиглэлийн ангийг тэр бүр сонгохгүй болсон өнөө үед оюутнуудыг газрын тосны үйлдвэрийн инженерийн ангид татан элсүүлэхдээ сургалтын төлбөрийг нь олгох нехцэл тавьсан.

УУХҮЯ, АМГТГ-аас сургалтын төлбөрийн санхүүжилтийг өнөөг хүртэл шийдвэрлээгүйгээс ШУТИС-ийн багш ажиллагсдыг болон ирээдүйд газрын тос боловсруулах аж үйлдвэрийн шинэ салбартаа ажиллахаар мэргэжлээ сонгосон залуучуудыг хүнд байдалд оруулж байна. Тулгамдаж буй дээрх асуудлуудыг төр засгийн түвшинд яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна.

## **Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн хангамжийн талаар**

Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдийг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн олборлолт явуулж буй Тосон-Уул XIX, Тамсаг ХХI талбайнуудаас хангах бөгөөд тус компанийн мэдэгдэж байгаагаар эдгээр хоёр талбайгаас нийтдээ жилд 700 мянга орчим тн газрын тос олборлохоор байна. Бид үйлдвэрийг 2025 онд ашиглалтанд оруулахаар төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд үйлдвэр ашиглалтад орохоос өмнө газрын тосны олборлолтын хэмжээг жилд 1.5 сая тн-д хүргэхийн тулд УУХҮЯ, АМГТГ-аас “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийг олборлолтоо орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хэмжээнд хүргэхийг шаардах, үйлдвэрийг түүхий эдээр тасралтгүй хангах талаар “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон түүний дээд шатны байгууллагатай яриа, хэлэлцээ хийж, санамж бичиг байгуулах, бусад БХГ-т талбайн хайгуулын ажлыг эрчимжүүлж, нөөц өсгөх арга хэмжээ авч ашиглах шаардлагатай байна.

Монгол улсын Засгийн газраас манай компанид олгосон газрын тосны хайгуул Давст ХХХI талбайд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-тай хамтран эрчимтэй хайгуул хийж, ойрын хугацаанд олборлолтод шилжүүлэх талаар удаа дараа санал солилцож байгаа бөгөөд тус компанийн зүгээс манай байгууллагатай хамтран газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийхэд толгой компани болох “Дачин Ойлфийлд” болон “Хятадын газрын тосны үндэсний корпораци”-ийн шийдвэр хэрэгтэй болохыг мэдэгдсэн. Тиймээс бид УУХҮЯ-аар дамжуулан ГХЯ, Монгол улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдад уг асуудлыг уламжилж өгөхийг хүссэн. Мөн МҮ-ын Ерөнхийлөгчийн БНХАУ-д хийсэн төрийн айлчлалын үеэр уулзалт, ярианы сэдэвт энэ асуудлыг тусгуулахаар хүргүүлсэн. Гэвч ямар нэгэн үр дүн гаррагүй байна. Давст ХХХI талбайд хайгуул, судалгааны ажил хийж, олборлолтод шилжүүлсэн ч үйлдвэрийг түүхий эдээр бүрэн хангахгүй юм. Иймд, үйлдвэр ашиглалтад орохоос өмнө үйлдвэрийн түүхий эдийг бүрдүүлэхийг газрын тосны асуудал хариуцсан төрийн байгууллагууд судалж, дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

**“МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨХХК**